



МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

Огноо 2022.04.06

№ 01

Улаанбаатар

Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ /цаашид “Холбоо” гэх/-ын Дүрмийн 6.5, 6.6, 6.8, 7.2.9, 7.3.1, 11.2, 11.3 дах заалтыг тус тус үндэслэл болгон ТОГТООХ нь:

1. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт Скай Ресортын “Хүн” театр хаягт зарлан хуралдуулсугай.
2. Бүх гишүүдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын үндэслэл, жагсаалтыг Хавсралт 1-р баталсугай.
3. Бүх гишүүдийн ээлжит бус хурлын төлөөлөгчдийн тоог 230 /хоёр зуун гуч/-р тогтоож, төлөөлөгч бүрт олгох 1 /нэг/ мандат саналын 1 /нэг/ эрхтэй байхаар тогтоосугай.
4. Бүх гишүүдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-ийг сонгох асуудлыг тусган багалж буйтай холбоотой нэр дэвшигчдэд тавих шаардлагын тухай журмыг Хавсралт 2-р баталсугай.
5. Бүх гишүүдийн хурлын зарыг хүргэх, сонгогдсон төлөөлөгчдийг бүртгэн мандат олгож хуралд оролцуулах, дэнчингээ зохих ёсоор төлж Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-д нэр дэвших шаардлага хангасан болон бүх гишүүдийн хурлын зохион байгуулалтын ажлыг хариуцан гүйцэтгэх Ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсугай:

Ажлын хэсгийн дарга: Т.Түвшинбаяр
Гишүүд: М.Отгонбаяр
С.Төгсжаргал
Ц.Мэргэн
Г.Батгөр
Б.Мэндсайхан
Ө.Мөнхчулуун

Ажлын хэсгийн нарийн бичиг: А.Даваабилэг

6. Бүх гишүүдийн ээлжит бус хурлын төлөөлөгчдийг сонгох журмыг Хавсралт 3-р баталсугай.

7. Бүх гишүүдийн ээлжит бус хурлын зарыг гишүүдэд хүргэж, энэхүү тогтоолын 5-д зааснаар сонгогдсон Төлөөлөгчдийг бүртгэн мандат олгож, мандат бүхий төлөөлөгчдийг Бүх гишүүдийн ээлжит бус хуралд оролцуулах болон Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зохион байгуулахтай холбоотой бүхий л арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг /Т.Түвшинбаяр/-т үүрэг болгосугай.

МОНГОЛЫН САГСАН
БӨМБӨГИЙН ХОЛБОО НҮТББ
ТОГТООЛЫГ БАТАЛСАН ТЭРГҮҮЛЭГЧИД

ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЦЭВЭРБАЛ


ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ДАМБА

ТЭРГҮҮЛЭГЧИД
Р.ЦЭВЭГМЭД
Д.ГООШООХҮҮ
Д.ДЭЛГЭРМАА
З.ГАЛЯ
М.ӨСӨХБАЯР
Б.МЭНДСАЙХАН
Т.ТҮВШИНБАЯР
Д.ЛХАГВА-ОЧИР



МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

Холбооны Тэргүүлэгчдийн
2022 оны 4-р сарын 6-ны өдрийн
01 дугаар тогтоолын Хавсралт 1



Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ-ын Бүх гишүүдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын үндэслэл, жагсаалт

Үндэслэл

Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ /цаашид “Холбоо” гэх/-ын тус Холбооны Дүрмийн 6.5, 6.6, 6.8, 7.2.9, 7.3.1-ын хүрээнд гаргасан Тэргүүлэгчдийн хурал /Удирдах зөвлөл/-ийн тогтоол болон ээлжит хурал дүрэмд заасан хугацаанд болоогүй, Холбооны Дүрмийн 6.11.1 болон 6.11.3 дах заалтаар Холбооны дүрмийн шинэчлэн батлах, Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Тэргүүлэгч /Удирдах зөвлөл/-ийн дийг сонгох, томилох, чөлөөлөх асуудлыг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр заасан нь Бүх гишүүдийн хурлын ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын үндэслэл болно.

Хэлэлцэх асуудлын жагсаалт

- Нэг. Бүх гишүүдийн ээлжит бус хурлын дэгийг батлах;
- Хоёр. Холбооны Дүрмийг шинэчлэн батлах;
- Гурав. Холбооны Ерөнхийлөгчийг сонгох, томилох, чөлөөлөх;
- Дөрөв. Холбооны Тэргүүлэгч /Удирдах зөвлөл/, Дэд Ерөнхийлөгч дийн сонгох, томилох, чөлөөлөх.

---oOo---



МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

МОНГОЛЫН САГСАН
БӨМБӨГИЙН ХОЛБОО НҮТББ

Холбооны Тэргүүлэгчдийн
2022 оны 04-р сарын ...-ны өдрийн
01 дугаар тогтоолын Хавсралт 2

УРААНБААТАР ХОТ
1115717928 Ф. 1016245

**Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ-ын
Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-ний
нэр дэвшигчдэд тавигдах шаардлагын тухай журам**

1. Энэхүү журмаар Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ /цаашид “Холбоо” гэх/-ын тус Холбооны Дүрмийн 6.5, 6.6, 6.8, 7.2.9, 7.3.1-ын хүрээнд гаргасан Тэргүүлэгчдийн хурал /Удирдах зөвлөл/-ын тогтоол болон Дүрмийн 7.4.12-т зааснаар Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-д нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, дэнчинтэй холбоотой харилцааг тодорхойлох ба Бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах Ажлын хэсэг мөрдөж ажиллана.
2. Холбооны Тэргүүлэгчдийн хурал /Удирдах зөвлөл/ нь 13 хүртэл гишүүнтэй байна.
3. Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-ийг 6 жилээр нэг удаа сонгоно.
4. Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нь Тэргүүлэгчдийн хурал /Удирдах зөвлөл/-ын гишүүн байна. Холбооны Ерөнхийлөгч нь Тэргүүлэгчдийн хурал /Удирдах зөвлөл/-ын дарга байна.
5. Холбооны Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Ажлын хэсгээс тогтоосон хугацааны дотор өөрийн мөрийн хөтөлбөр болон холбогдох материалыг хүргүүлж, 80,000,000 /наян сая/ төгрөгийн дэнчинг холбогдох дансанд байршуулсан байна. Ерөнхийлөгчөөр сонгогдсон тохиолдолд жил бүр 80,000,000 /наян сая/ төгрөгийг Холбооны үйл ажиллагааны санхүүжилтэд зориулан хандивлана. Нэр дэвшигч нь сонгогдоогүй тохиолдолд 20,000,000 /хорин сая/ төгрөгийг Холбооны үйл ажиллагааны санхүүжилтэд хандивласнаар тооцож, үлдэх 60,000,000 /жаран сая/ төгрөгийг буцаан олгоно.
6. Холбооны Дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Ажлын хэсгээс тогтоосон хугацааны дотор холбогдох материалыг хүргүүлж, 20,000,000 /хорин сая/ төгрөгийн дэнчинг холбогдох дансанд байршуулсан байна. Дэд Ерөнхийлөгчөөр сонгогдсон тохиолдолд жил бүр 20,000,000 /хорин сая/ төгрөгийг Холбооны үйл ажиллагааны санхүүжилтэд зориулан хандивлана. Нэр дэвшигч нь сонгогдоогүй тохиолдолд 5,000,000 /таван сая/ төгрөгийг Холбооны үйл ажиллагааны санхүүжилтэд хандивласнаар тооцож, үлдэх 15,000,000 /арван таван сая/ төгрөгийг буцаан олгоно.
7. Ажлын хэсгээс Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг Бүх гишүүдийн хуралд танилцуулж нэг хүнийг Холбооны Бүх гишүүдийн хурлаар олонхийн саналаар сонгоно.
8. Ажлын хэсгээс Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-д нэр дэвшигчдийг Бүх гишүүдийн хуралд танилцуулж нийт 6 хүртэл хүнийг Холбооны Дэд Ерөнхийлөгч болох Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-нээр Холбооны Бүх гишүүдийн хурлаар олонхийн саналаар сонгоно. Мөн ижил тооны Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/-ээр Холбооны гишүүнчлэлтэй, сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг холбоодыг Холбооны Бүх гишүүдийн хурлаар олонхийн саналаар сонгоно.
9. Холбооны Тэргүүлэгчдийн хурал /Удирдах зөвлөлийн хурал/-д Холбооны гишүүнчлэлтэй, сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг холбоог төлөөлж тухайн холбооноос итгэмжлэгдсэн нэг хүн оролцоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тухайн холбооны удирдах албан тушаалтан байх шаардлагатай /Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүн/.



МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2022 оны 04-р сарын 17-ны өдрийн
01 дугаар тогтоолын Хавсралт 3

Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ-ын Бүх гишүүдийн ээлжит бус хурлын төлөөлөгчдийг сонгох журам

1. Энэхүү журмаар Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ /цаашид “Холбоо” гэх/-ын тус Холбооны Бүх гишүүдийн хурлын төлөөлөгчдийн сонгох, сонгогдсон төлөөлөгчдөд мантад олгон хуралд оролцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

2. Холбооны гишүүнчлэлтэй, сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг дор дурдсан холбоо нь тус бүр өөрт ногдох тооны хүнийг Холбооны Бүх гишүүдийн хурлын төлөөлөгчөөр ажиллуулах хүсэлтээ албан бичгээр Холбооны Бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах Ажлын хэсэг /“Ажлын хэсэг”/-т ирүүлнэ.

Холбооны нэр	Бүх гишүүдийн хуралд оролцуулах төлөөлөгчдийн тоо
Монголын Үндэсний Сагсан Бөмбөгийн холбоо	20 хүн
Монголын 3x3 Сагсан Бөмбөгийн холбоо	40 хүн
Их дээд сургуулийн Сагсан Бөмбөгийн холбоо болон Оюутны Сагсан бөмбөгийн холбоо	20 хүн
Монголын Тамирчдын Сагсан Бөмбөгийн холбоо болон Монголын Тамирчдын “Ирээдүй” Холбоо	50 хүн
Өсвөр үеийн Сагсан Бөмбөгийн холбоо болон Сонирхогчийн Сагсан Бөмбөгийн холбоо	20 хүн
Шүүгчдийн төлөөлөл	10 хүн
Ахмадын төлөөлөл	40 хүн
Багийн дасгалжуулагч болон Багийн эзэд	20
Тэргүүлэгч /Удирдах зөвлөлийн гишүүн/	10

3. Ажлын хэсэг нь Холбооны гишүүнчлэлтэй, сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг холбооноос албан ёсоор бичгээр тодорхойлж ирүүлсэн дээрх тооны хүнд Бүх гишүүдийн хурлын мандатыг хуваарийн дагуу олгож хуралд оролцуулна.

---oOo---